




9-11 нас

ХҮҮХДЭД зориулсан зурган библи

Бүтээлч ном

Хуучин гэрээ
3



Хүүхдэд зориулсан зурган библи

Бүтээлч ном **Хуучин гэрээ 2**

9-11 нас

Эмхэтгэсэн

|  kidsworship

 Selah
Ministry of Christian Publishing

Орчуулагч | N.Soninbayar, Н. Сонинбаяр | График дизайнер | Jeewon Park, Julio Blas | Засварласан | N.Soninbayar, Н. Сонинбаяр

Энэ номыг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр бүхэлд нь болон хэсэгчлэн хуулбарлахыг хориглоно.

ГАРЧИГ



1. Ханна ба Самуел	6
2. Давид ба Голиат	10
3. . Давид ба Ионатан	15
4. Соломон	20
5. Елиа	24
6. Нааман жанжин	28
7. Естер хатан	32
8. Иов	36
9. Даниел	40
10. Иона	43









Миний ахиц дэвшил



Тухайн библийн түүхийг үзэж дуусгасны дараа библийг өнгөөр ялган будаарай.



QR кодыг
уншуулан дараах
видеог үзээрэй.



Түүх 1 : Ханна ба Самуел

Библийн эшлэл
[1Самуел 1:11]

Тэр ам өчиг өгөн – Түг түмдийн ЭЗЭН минь, хэрэв Та шивэгчнийхээ зовлон зүдүүрийг үзээд, намайг санаж, шивэгчнээ үл мартан шивэгчиндээ хөвгүүнийг өгвөл, би түүнийг амьдралынх нь бүх өдрүүдэд ЭЗЭНд өгөх бөгөөд түүний толгойд тонгорог ч хүргэхгүй.

Израильд Елкана гэдэг хүн байжээ. Елкана хоёр эхнэртэй байсан бөгөөд нэгнийх нь нэр Ханна, нөгөөгийнх нь нэр Пенинна гэдэг байжээ. Пенинна олон хүүхэдтэй байсан ч Ханна хүүхэдгүй байв. Харин Пенинна Ханнаг хүүхэдгүйгээр нь ихэд дээрэлхдэг байв.

Гэвч Елкана Ханнаг маш ихээр хайрладаг байжээ.

Үүнийг мэдэж байсан Пенинна улам ихээр уурлан Ханнаг үргэлж зовоодог байжээ.

Ханна хүүхэдгүйгээсээ болж сэтгэл нь урагдах мэт өвддөг байлаа.

Ханна сүмд очин Бурханы өмнө уйлан залбирчээ. Ханна маш удаан хугацаанд Бурханд залбирчээ.

Энэ үед тахилч Ели сүмд орж ирэв.

Ханна маш удаан залбирсанаас болж дуу нь ч гарахгүй зөвхөн уруул нь хөдөлж байлаа. Ели түүнийг дарсанд согтсон гэж боджээ. Ханна тахилчид ингэж хэлэв.

“Тахилч минь би дарсанд согтоогүй. Харин сүнс минь маш их шаналж байна. Тэгээд Бурханд залбирч байна.”

Ханнагийн яриаг сонсоод Ели түүнийг ерөөж өгөв. Ханна маш их талархаж тэр газраас холдон явав.

Түүнээс хойш Ханна хоол үнд идэж, дахин санаа зовохоо больжээ. Бурхан Ханнаг буцаж санав.

Гэртээ буцаж ирээд төд удалгүй Ханна жирэмсэн болов. Цаг нь болж тэрээр хүү төрүүлжээ. Хүүг Самуел гэж нэрлэв.

Ханна хүү Самуелийгаа хөхнөөс нь гаргах хүртэл хичээнгүйлэн хайрлан өсгөжээ.

Тэгээд Самуелыг хөхнөөс нь гармагц, Бурханд амласнаараа түүнийг дагуулан сүмд очив.

Бяцхан Самуел тахилч Елитэй хамт Бурханд үйлчлэн сүмд амьдрах болжээ.

Самуел өсөн том болж, өдөр бүр Бурхантай хамт байхдаа дуртай байлаа.


Самуелыг өсөж том болох цаг мөч бүрд Бурхан түүнтэй хамт байв.

Ийнхүү бүх Израиль Самуелыг Эзэний эш үзүүлэгч мөн болохыг ойлгов.

Тэрээр Бурханы үгээр ард олныг удирдаж байсан төдийгүй Израилийн хаадыг тосолжээ.

Үүгээр ч зогсохгүй Самуел ард түмэнд Бурханы үгийг зааж, дамжуулдаг агуу нэгэн болсон юм.





— Хайчлах шугам
- - - - - Нугалах шугам

Жишээ зураг



а. Ханна хамгийн хэцүү байдалд байх үедээ хаана залбирсан бэ?

б. Ханна хүү төрүүлээд хэн гэж дуудсан бэ?

с. 1Самуел 1:9-18 эшлэлийг уншаад хариулаарай. Ханна залбирч байх үедээ Бурханд юу гэж амласан бэ?

● Дараах эшлэлийг уншаад цээжлээрэй. (1Самуел 1:11)

Шивэгчиндээ хөвгүүнийг өгвөл, би түүнийг амьдралынх нь бүх өдрүүдэд ЭЗЭНд өгөх бөгөөд түүний толгойд тонгорог ч хүргэхгүй гэв